



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/428

Арвайхээр

Газар эзэмших эрх шинээр олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 13 дугаар баг Т.Намнансүрэнгийн 7 дугаар гудамж аймгийн Мэргэжлийн хяналтын газрын урд Өвөрхангай аймгийн Зоонозын өвчин судлалын төв (РД9045966)-д 2880 м² газрыг эрүүл мэндийн байгууллагын зориулалтаар, мөн тус байршилд Голын чулуу ХХК (3557731)-д 1000 м² газрыг худалдаа, үйлчилгээний төв цогцолборын зориулалтаар тус тус 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/350 дугаар захиарамжийн Өвөрхангай аймгийн Зоонозын өвчин судлалын төвд холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Дээрх газар эзэмших эрх авсан хуулийн этгээдтэй газар эзэмших гэрээг байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100953